

**ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-103-ЫН ХАРЬЦУУЛАЛТ**

<p><b>Хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагааны дүрэм</b> (Шинэчлэгдэж байгаа) /15 хуудас/2011 оны NZ amend.7</p>	<p><b>ХЭТ ХӨНГӨН АГААРЫН ХӨЛӨГ - ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /13 хуудас (үндсэн дүрэм-25 хуудастай байсан)/1997 оны NZ amend.4</p>	<p><b>Тайлбар</b></p>
<p><b>А Бүлэг - Ерөнхий зүйл</b></p>	<p><b>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b></p>	
<p><b>103.1. Хамрах хүрээ</b> Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) ИНД-91-ийн шаардлагаас гадна, <b>хэт хөнгөн агаарын хөлгийн</b> үйл ажиллагааны нэмэлт шаардлага; (2) ИНД-91-д <u>үл хамаарах</u> хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагааны шаардлага ; (3) хэт хөнгөн агаарын хөлгийн НТЧ-ын болон техник үйлчилгээний шаардлага.</p>	<p><b>103.1. Зорилго</b> (а) Энэ дүрмийн зорилго нь: 1/ <b>хэт хөнгөн агаарын хөлгийн</b> үйл ажиллагаанд хамаарах ИНД-91-ийн нэмэлт журмыг тогтоох; 2/ ИНД-91-ийн <b>зарим заалтаас</b> хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагааг <b>чөлөөлөх</b>; 3/ хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын болон засвар үйлчилгээнд тавигдах шаардлагыг тогтоох; 4/ энэ дүрмийн дагуу гэрчилгээжсэн хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.</p>	<p>-“ИНД-91-ийн зарим заалтаас хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагааг <b>чөлөөлөх</b>” гэснийг <u>“Үл хамаарах”</u> гэж залруулсан</p>
<p><b>103.3. Нэр томъёо ба товчлол</b> <u>Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</u></p>		<p>-Нэр томъёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p><b>103.5. Нисгэгчид тавих шаардлага</b> (а) Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчийн үүрэг гүйцэтгэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна: (1) зохих маягийн зэрэглэлтэй <b>хэт хөнгөн агаарын хөлгийн</b> нисгэгчийн хүчинтэй үнэмлэх эзэмшдэг байх; эсхүл (2) ИНД-61-ийн дагуу, зохих маягийн зэрэглэлтэй нисгэгчийн хүчинтэй үнэмлэх эзэмшдэг байх; эсхүл (3) 103.7-гийн шаардлагыг хангасан хэт хөнгөн агаарын хөлгийн Сургагч-нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийн шууд хяналтад үйл ажиллагаа гүйцэтгэдэг байх.</p>	<p><b>103.3. Нисгэгчид тавигдах шаардлага</b> (а) Хэт хөнгөн агаарын хөлгөөр нислэг үйлдэх этгээд нь:  1/ хэт хөнгөн агаарын хөлгийн зохих маягийн зэрэглэлтэй, нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байна, эсхүл 2/ ИНД-61-ийн дагуу, зохих маягийн зэрэглэл бүхий нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байна, эсхүл 3/ энэ дүрмийн 103.5-д заагдсан шаардлагыг хангасан багш нисгэгчийн шууд хяналтанд байгаа <b>сурагч</b> байна.</p>	<p>-Орчуулга найруулга зассан.</p>

(b) Нисгэгч нь үнэмлэх, эсхүл гэрчилгээ болон холбогдох маягийн зэрэглэлийн эрх, хязгаарлалтыг дагаж мөрдөнө.

(б) Нисгэгч нь үнэмлэх болон зохих зэрэглэлээр олгогдсон эрх, хязгаарлалтын хүрээнд нислэгийн үйл ажиллагаанд оролцоно.

**103.6. Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч (шилжилт)**

Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь дараах үнэмлэх, эсхүл гэрчилгээ болон холбогдох зэрэглэл эзэмших үүрэгтэй:

- (1) сурагч-нисгэгчийн үнэмлэх;
- (2) А, В, С бүлгийн сурагч-нисгэгчийн зэрэглэл;
- (3) дунд түвшний нисгэгчийн үнэмлэх;
- (4) А, В, С бүлгийн дунд түвшний нисгэгчийн зэрэглэл;
- (5) ахлах нисгэгчийн үнэмлэх;
- (6) А, В, С бүлгийн ахлах нисгэгчийн зэрэглэл;
- (7) хэт хөнгөн агаарын хөлгийн Сургагч-нисгэгчийн гэрчилгээ;
- (8) А, В, С бүлгийн хэт хөнгөн агаарын хөлгийн Сургагч-нисгэгчийн зэрэглэл;
- (9) эрх бүхий шалгагч (АТО).

- Part 19-өөс шилжүүлсэн

**103.7. Нислэгийн зааварчилгаа**

Ашиглагдаж байгаа хэт хөнгөн агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг, зохих сургалтад хамрагдаж эрх авсан бөгөөд дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд аливаа этгээд хэт хөнгөн агаарын хөлгийн Сургагч-нисгэгчийн эрхийг хэрэгжүүлэхгүй:

- (1) тухайн этгээд нь:
  - (i) хэт хөнгөн агаарын хөлгийн Сургагч-нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;
  - (ii) тухайн үйл ажиллагааг удирдаж байгаа хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагын Ерөнхий зааварт заасан журмын шаардлагыг хангасан байх; эсхүл
- (2) тухайн этгээд нь:
  - (i) ИНД-61-ийн дагуу олгосон багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх;
  - (ii) хэт хөнгөн агаарын хөлгийг жолоодох ур чадвараа энэ зүйлийн (1)-д заасан хэт

**103.5. Нислэгийн зааварчилгаа**

(a) Хэт хөнгөн агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшээгүй, зохих сургалтанд хамрагдаж багшлах эрх олгогдоогүй этгээдийг хэт хөнгөн агаарын хөлгийн багш Нисгэгчээр томилохгүй.

- (б) Энэ зүйлийн (a)-д заасан этгээд нь:
  - 1/ хэт хөнгөн агаарын хөлөг дээр багшлах эрхтэй байна,
  - 2/ хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын зааварт тусгагдсан журмыг дагаж мөрдөнө; эсхүл
  - 3/ ИНД-61-ийн дагуу, багшлах зэрэглэл эзэмшсэн,
  - 4/ хэт хөнгөн агаарын хөлгийг жолоодох ур чадвартай гэдгээ харуулсан байна.

-Орчуулга найруулга зассан.

хөнгөн агаарын хөлгийн Сургагч-нисгэгчид шалгуулсан байх.		
<b>103.9. Нислэгийн радио холбооны операторын шаардлага</b> ИНД-61.153(а)(6)(vi)-гийн дагуу шаардсан нислэгийн радио холбооны бичгийн шалгалтад тэнцэж эрх авснаас бусад тохиолдолд хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь нисэхийн радио холбооны дамжуулагч-хүлээн авагч ашиглахгүй <a href="#">байх үүрэгтэй.</a>	<b>103.7. Радио холбоо ашиглах зөвшөөрөл</b> (а) Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь холбогдох Иргэний нисэхийн багц дүрэм (цаашид ИНБД гэх)-ийн шаардлагын дагуу нислэгийн радио холбооны операторчийн зэрэглэл эзэмшээгүй бол аэронавигацийн радио дамжуулагч ашиглахыг <a href="#">зөвшөөрөхгүй</a>	-Орчуулга найруулга зассан.
<b>В Бүлэг - [Нөөц]</b>		
<b>С Бүлэг - [Нөөц]</b>		
<b>Д Бүлэг - [Нөөц]</b>		
<b>Е Бүлэг- Үйл ажиллагааны <a href="#">дүрэм</a></b>	<b>Д БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ <a href="#">ЖУРАМ</a></b>	
<b>103.101. Бүртгэл</b> (а) Хэт хөнгөн агаарын хөлөгт ИНД-47-гийн дагуу бүртгэлийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Даргад тухайн агаарын хөлөг дараах шаардлага хангаж байгааг нотлох баримтыг хүргүүлнэ: (1) <a href="#">хэт хөнгөн агаарын хөлгийн хувьд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц бага үндсэн үзүүлэлттэй болон төвлөрөлтийн хялбар параметртэй байх; эсхүл</a> (2) 103.207(а)(1)(ii)-т заасан маягийн загварын стандартад нийцэж байх. (б) Бүртгэлд зөвшөөрөгдсөн хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн агаарын хөлөг энэ зүйлийн (а)-ийн шаардлагыг байнга хангаж байгааг бататгана.	<b>103.107. <a href="#">Агаарын хөлгийн</a> бүртгэл</b> (а) Хэт хөнгөн агаарын хөлөгт ИНД-47-гийн дагуу бүртгэлийн гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь уг агаарын хөлгийн хувьд дараах баримтыг бүрдүүлнэ: 1/ <a href="#">ИНЕГ-аас хэт хөнгөн агаарын хөлгийн нислэг-техникийн үндсэн үзүүлэлтэд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэх, эсхүл</a> 2/ энэ дүрмийн 103.203-ын (а)-гийн 1/-ийн 1.2 -т заагдсан маягийн загварын стандартад нийцэж байгаа эсэх. (б) Бүртгэлд зөвшөөрөгдсөн хэт хөнгөн агаарын хөлгийг ашиглагч нь тухайн агаарын хөлгийг энэ зүйлийн (а)-д заагдсан шаардлагыг тогтмол хангаж байгаа эсэхэд хариуцлага хүлээнэ.	-Орчуулга найруулга зассан.
<b>103.103. Агаарын хөлгийн нислэгийн заавар</b> ИНД-91.109-ийн шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.	<b>103.113. Агаарын хөлгийн нислэгийн <a href="#">ашиглалтын заавар</a></b> (а) ИНД 91-д заасан шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгийг ашиглагчид хамаарахгүй.	-Орчуулга найруулга зассан.

<p><b>103.105. <u>Бүхээгт авч явах</u> баримт бичиг</b>  (a) ИНД-91.111-ийн шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.  (b) <u>103.203(b)-ээр</u> шаардсан нислэгийн зөвшөөрлийг тухайн агаарын хөлөгт авч явахаас бусад тохиолдолд аливаа этгээд Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөг, эсхүл Ангилал-1 хэт хөнгөн нисдэг тэргээр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.</p>	<p><b>103.114. <u>Агаарын хөлөгт байх</u> бичиг баримт</b>  (a) ИНД 91-д заасан шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгийг ашиглагчид хамаарахгүй.  (b) Аливаа этгээдийг энэ дүрмийн <u>103.199-ийн (б)-д</u> шаардсан, нислэгийн зөвшөөрөлгүй 2-р ангиллын хэт хөнгөн агаарын хөлгөөр, эсхүл 1-р ангиллын хэт хөнгөн нисдэг тэргээр нислэг үйлдэхийг хориглоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p>
<p><b>103.107. <u>Зурагт хуудас (Placards)</u></b>  (a) Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь дараах мэдээллийг харуулсан, ойлгомжтой зурагт хуудсыг тухайн нисгэгчид ил харагдахаар байрлуулсан болохыг бататгана:  (1) гэрчилгээжсэн, эсхүл загварын нийт жингийн аль багыг;  (2) тухайн агаарын хөлгийн ашигт ачааллын максимум болон минимум хэмжээг.  (b) Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь дараах мэдээлэлийг агуулсан ойлгомжтой зурагт хуудсыг сууж байгаа зорчигчид ил харагдахаар байрлуулсан болохыг бататгана:  (1) зурагт хуудас нь “зорчигчид анхааруулах нь” гэсэн зөвлөсөн гарчигтай;  (2) тухайн агаарын хөлөгт НТЧ-ын гэрчилгээ шаардлагагүй болохыг мэдэгдсэн.</p>	<p><b>103.115. <u>Тэмдэглэгээ ба зурагт хуудас</u></b>  (a) Гэрчилгээ эзэмшигч нь 2-р ангиллын хэт хөнгөн агаарын хөлгийн бүхээгт нисгэгч ид харагдахуйц газарт дараах тэмдэглэгээг байрлуулсан байна:  1/ агаарын хөлгийн загварын, эсхүл гэрчилгээт жингийн аль бага жин, ба  2/ тухайн агаарын хөлгийн хувьд ашигт ачааллын дээд ба доод хязгаар.  (b) Гэрчилгээ эзэмшигч нь 2-р ангиллын хэт хөнгөн агаарын хөлгийн бүхээгт, зорчигчид харагдахуйц газарт дараах тэмдэглэгээ болон зурагт хуудсыг байрлуулсан байна:  1/ зорчигчдод хандсан анхааруулга болон зөвлөмж,  2/ уг агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ шаардагдахгүй гэсэн бичилт</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p>
<p><b>F Бүлэг - Нислэгийн <u>дүрэм</u></b></p>	<p><b>E БҮЛЭГ. НИСЛЭГИЙН <u>ЖУРАМ</u></b></p>	
<p><b>103.151. <u>Түлшний</u> шаардлага</b>  ИНД-91.305-ын шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчид хамаарахгүй.</p>	<p><b>103.151. <u>Шатахуунд тавигдах</u> шаардлага</b>  (a) ИНД 91-д заасан шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчид хамаарахгүй.</p>	
<p><b>103.153. <u>Минимум</u> өндөр</b>  ИНД-91.311-т заасныг үл харгалзан, хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь газрын түвшнээс дээш 150 м-ээс (500 ft) нам өндөрт дараах зорилгоор нислэг үйлдэж болно:  (1) хэт хөнгөн -жиропланы аэродромын хайрцаг</p>	<p><b>103.153. <u>Хамгийн нам</u> өндөр</b>  (a) ИНД 91-т заасныг үл хамааран, хэт хөнгөн агаарын хөлгөөр дараах зорилгоор 150 метр (500 фут)-ээс нам өндөрт нислэг үйлдэхийг зөвшөөрнө.  1/ газрын гадаргуугаас дээшхи <u>50</u> метр (200 фут)-</p>	<p>-Орчуулга найруулга зассан  -“Минимум”-ыг “хамгийн нам” гэснийг “минимум” гэж өөрчлөгдсөн</p>

<p>нислэгийн сургалтыг AGL <u>60 м</u>-ээс (200 ft) нам өндөрт хийгээгүй бол;</p> <p>(2) хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн тэмцээний бэлтгэл хийх болон түүнд оролцох дараах үйл ажиллагаа нь:</p> <p>(i) хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагын зөвшөөрөл болон тодорхой ойлголт, мэдлэгийн дагуу явагдаж байгаа бол;</p> <p>(ii) хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагын тогтоосон нөхцөлийн дагуу зохион байгуулагдаж байгаа бол;</p> <p>(iii) AGL <u>60 м</u>-ээс (200 ft) нам өндөрт үйлдэгдээгүй бол.</p>	<p>ээс доошгүй нам өндөрт хэт хөнгөн сэнст төхөөрөмж (gyroplane)-өөр үйлдэх сургалтын нислэг;</p> <p>2/ дараах тохиолдолд хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн тэмцээний үед болон бэлтгэл сургуулалтын нислэг;</p> <p>2.1 хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын удирдлага, зөвшөөрлийн дагуу явагдаж байгаа үйл ажиллагаа;</p> <p>2.2 хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагаас тавьсан нөхцөл, шаардлагын дагуу зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаа;</p> <p>2.3 газрын гадаргуугаас дээш <u>50</u> метр (200 фут)-ээс доошгүй өндөрт үйлдэгдэх нислэг.</p>	<p>-“50 метр” гэснийг “60 м-ээс” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>103.155. <u>Нислэгийн шалгуур</u></b></p> <p>(a) Нисгэгч нь, зөвхөн дараах нөхцөлд хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэнэ:</p> <p>(1) өдрөөр;</p> <p>(2) <u>ИНД-91.301</u>-д заасантай ижил, эсхүл илүү сайн VFR-ийн цаг уурын минима-д.</p> <p>(b) Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь дараах нөхцөлд үйл ажиллагаа эрхлэхгүй:</p> <p>(1) хот, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр; эсхүл</p> <p>(2) дараахаас бусад тохиолдолд, хяналттай агаарын зайд, эсхүл ИНД-139-ийн дагуу гэрчилгээжсэн аэродромоос 5.5 км-ийн (3 nm) зайд:</p> <p>(i) тухайн нисгэгч нь <u>61.153(a)(6)(i)-д</u> шаардсан нисэхийн хууль дүрмийн, эсхүл түүнтэй дүйцэх шалгалт өгч тэнцсэн байх; эсхүл</p> <p>(ii) тухайн нисгэгч нь энэ зүйлийн (b)(2)(i)-ийн шаардлагыг хангасан хэт хөнгөн агаарын хөлгийн Сургагч-нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийн шууд хяналтад байх.</p> <p>(c) Дараахаас бусад тохиолдолд, нисгэгч нь энэ</p>	<p><b>103.155. <u>Хэт хөнгөн агаарын хөлгөөр нислэг үйлдэх</u></b></p> <p>(a) Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь:</p> <p>1/ зөвхөн өдрийн цагт нислэг үйлдэнэ;</p> <p>2/ ил харааны дүрмээр нислэг үйлдэх цаг уурын нөхцөлд, эсхүл <u>ИНД-91</u>-д зааснаас дээш үзүүлэлттэй нөхцөлд нислэг үйлдэнэ.</p> <p>(б) Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь:</p> <p>1/ хот суурин газар, хүн ам шигүү суурьшсан нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэхгүй;</p> <p>2/ дараах шаардлагыг хангасан тохиолдолд ИНД-139-ийн дагуу гэрчилгээжсэн аэродромоос 5,5 км (3 nmile)-д буюу удирдлагатай агаарын зайд нислэг үйлдэнэ:</p> <p>2.1 <u>ИНД-61</u>-д заасан нисэхийн хууль тогтоомжийн шалгалт, эсхүл ижил төрлийн шалгалт өгсөн, эсхүл</p> <p>2.2 энэ зүйлийн 2/-ын 2.1 -д заагдсан шаардлагыг хангасан багш нисгэгчийн шууд хяналтанд.</p> <p>(в) Дараах шаардлага хангагдаагүй тохиолдолд нисгэгч</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p> <p>-Бусад дүрэм рүү ишлэл хийсэн заалтуудыг орхигдуулсныг нэмж оруулсан</p>

зүйлийн (b)(2)(ii)-ын дагуу үйл ажиллагаанд оролцохгүй бөгөөд, хянаж байгаа Сургагч-нисгэгч нь тухайн үйл ажиллагааг зөвшөөрөхгүй:

- (1) тухайн Сургагч-нисгэгч нь агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэх холбогдох агаарын зайд хамаарах ИНД-ийг мөрдөх талаар нисгэгчид бүрэн зааварчилгаа өгсөн байх;
- (2) нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнээс тухайн үйл ажиллагааны нислэгийн өмнөх зааварчилгаа авсан байх.

нь энэ зүйлийн (б)-гийн 2/-ын 2.2-ын дагуу нислэгийн үйл ажиллагаанд оролцож болохгүй бөгөөд багш нисгэгч нь тухайн нислэгийг зөвшөөрч болохгүй:

- 1/ нисгэгч нь багш нисгэгчээс нислэг үйлдэх тухайн агаарын зайд хүчин төгөлдөр үйлчилж буй дүрмийн талаар бүрэн зааварчлага аваагүй бол,
- 2/ нислэгийн өмнө, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас тухайн нислэгийн талаар бүрэн мэдээлэл өгөгдөөгүй бол.

### 103.157. Ханг-глайдер чирэх

(a) Нислэгт ханг-глайдер чирэх хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь хэт хөнгөн агаарын хөлгийн ахлах нисгэгчээс (advanced) доошгүй нисгэгчийн үнэмлэх, эсхүл ИНД-61-ийн дагуу олгосон үнэмлэх болон хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагаас олгосон ур чадварын мэдэгдэл хэлбэрээр нисгэгчийн дэвтэртээ тэмдэглүүлсэн ханг-глайдер чирэх зэрэглэл эзэмшдэг байна.

(b) Хэт хөнгөн агаарын хөлгийн ахлах нисгэгчийн (advanced) үнэмлэх эзэмшигч, эсхүл ИНД-61-ийн дагуу олгосон үнэмлэхтэй нисгэгч нь дараах шаардлагыг хангасан бол, хэт хөнгөн агаарын хөлөг чирэх зэрэглэл авах эрхтэй:

- (1) 100-гаас доошгүй цагийн нислэгийн туршлагатай байх ба үүний:
  - (i) 80-аас доошгүй цагт нь хэт хөнгөн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн;
  - (ii) 20-иос доошгүй цагт нь ашиглаж байгаа маягийн хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн;
- (2) ханг-глайдерын байгууллагын хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэдэг бөгөөд Даргын шилжүүлсэн эрх эзэмшигчийн олгосон ханг-глайдерын Сургагч-нисгэгчийн үнэмлэх эзэмшигчээс ханг-глайдер чирэх үеийн онцгой

### 103.157. Дельтаплан чирэх

(a) Дельтаплан чирэх хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь ИНД-61-ийн дагуу олгогдсон үнэмлэхтэй, эсхүл хэт хөнгөн агаарын хөлгийн өндөр зэрэглэлийн гэрчилгээтэй байх ба хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагаас "дельтаплан чирэх зэрэглэл олгосон" тухай бичилтийг нислэгийн дэвтэртээ хийлгэсэн байна.

(б) Дараах шаардлагыг хангасан, ИНД-61-ийн дагуу олгогдсон үнэмлэхтэй, эсхүл хэт хөнгөн агаарын хөлгийн өндөр зэрэглэлийн гэрчилгээтэй нисгэгчид дельтаплан чирэх зэрэглэл олгоно:

- 1/ 100-гаас доошгүй цагийн нислэгийн дадлага туршлагатай байх ба үүнээс:
  - 1.1 80-аас доошгүй цагт нь хэт хөнгөн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн,
  - 1.2 20-иос доошгүй цагт нь нислэг үйлдэх тухайн хэт хөнгөн агаарын хөлөг дээр нислэг үйлдсэн байна;
- 2/ нисгэгч нь, дельтаплан чирэх үеийн онцгой тохиолдлын болон үйл ажиллагааны журмын талаар дельтапланы эрх бүхий багш нисгэгчээс зааварчилгаа авсан;

-Орчуулга найруулга зассан  
- “Дельтаплан” гэснийг “Ханг-глайдер” гэж өөрчилсөн  
- микролайтын гэрчилгээний шаардлага шинээр нэмэгдсэн

<p>нөхцөл болон журмын талаар зааварчилгаа авсан байх;</p> <p>(3) хэт хөнгөн агаарын хөлгийн Сургагч-нисгэгчийн үнэмлэх эзэмшигчээс, хэт хөнгөн агаарын хөлөг чирэх онцгой нөхцөл журмын талаар зааварчилгаа авсан байх.</p> <p>(с) Дараахаас бусад тохиолдолд, хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь нислэгт <b>ханг-глайдер</b> чирэхгүй:</p> <p>(1) чирж байгаа агаарын хөлгийн тухайн маяг нь чирэгдэж байгаа <b>ханг-глайдер</b>ын үзүүлэлтэд заасан, агаарт чирэгдэн нисэх зөвшөөрөгдөхүйц максимум хурднаас бага хурданд удирдлагатай нислэг үйлдэх чадвартай байх;</p> <p>(2) чирж байгаа агаарын хөлөг нь 103.223-т заасан төхөөрөмжийн шаардлага хангадаг байх;</p> <p>(3) хоёр агаарын хөлгийн холбоосыг салгах механизмын ажиллагаатай байдлыг, тухайн өдрийн эхний нислэгийн өмнө шалгасан байх.</p>	<p>3/ хэт хөнгөн агаарын хөлгөөр <b>дельтаплан</b> чирэх үеийн онцгой тохиолдлын болон үйл ажиллагааны журмын талаар хэт хөнгөн агаарын хөлгийн эрх бүхий багш нисгэгчээс зааварчилгаа авсан байна.</p> <p>(в) Нисгэгч нь дараах шаардлагыг хангаагүй хэт хөнгөн агаарын хөлгөөр <b>дельтаплан</b> чирэхгүй:</p> <p>1/ чирж буй агаарын хөлөг нь маягийн хувьд, чирүүлэх <b>дельтапланы</b> тодорхойлолтод зөвшөөрөгдсөн хамгийн их чирэх хурднаас бага хурд дээр тогтвортой удирдагдаж нислэг үйлдэх чадвартай байх;</p> <p>2/ чирж буй агаарын хөлөг нь энэ дүрмийн 103.321-д заасан, тоног төхөөрөмжид тавигдах шаардлагыг хангасан байх;</p> <p>3/ тухайн нислэгээс өмнө, чирж байгаа болон чирэгдэж байгаа агаарын хөлгүүдийн холбоос салгах механизмын ажиллагааг шалгасан байх.</p>	
<p><b>103.159. Зорчигч тээвэрлэх</b> Дараахаас бусад тохиолдолд, нисгэгч нь хэт хөнгөн агаарын хөлөгт бусад этгээдийг тээвэрлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллага тухайн нисгэгчид зорчигч тээвэрлэх эрх олгосон байх; эсхүл</p> <p>(2) <a href="#">тухайн агаарын хөлөг нь ИНД-115-ын дагуу Даргаас олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байх;</a></p> <p>(3) тухайн агаарын хөлөг нь Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөг байх;</p> <p>(4) тухайн агаарын хөлөг нь 103.213-ын дагуу холбогдох техник үйлчилгээний бүртгэлд бичилт хийж оруулсан НТЧ-ын мэдэгдэлтэй байх.</p>	<p><b>103.159. Зорчигч тээвэрлэх</b> (а) Нисгэгч нь дор дурдсанаас бусад тохиолдолд хэт хөнгөн агаарын хөлгөөр аливаа этгээдийг тээвэрлэхгүй:</p> <p>1/ хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагаас зөвшөөрсөн бол;</p> <p>2/ агаарын хөлөг нь 2-р ангиллын хэт хөнгөн агаарын хөлөг бол;</p> <p>3/ хэт хөнгөн агаарын хөлгийн техник үйлчилгээний баримт бичигт энэ дүрмийн 103.313-ын дагуу нислэгт тэнцэх чадварын талаар зохих тэмдэглэл хийгдсэн бол.</p>	<p>- Орчуулга найруулга зассан.</p> <p>- “ИНД-115-ын гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа бол” гэсэн нөхцөл шинээр нэмэгдсэн</p>
<p><b>G Бүлэг - НТЧ болон техник үйлчилгээ</b></p>	<p><b>Ж БҮЛЭГ. НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАР БА ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ</b></p>	
<p><b>103.201. Тодорхойлолт</b></p>	<p><b>103.197. Тодорхойлолт</b></p>	<p>-Amend.6-аар өөрчлөгдсөн</p>

<p>Энэ Бүлгийн Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөгт Ангилал-1 хэт хөнгөн нисдэг тэрэг багтана.</p>	<p>(a) Энэ бүлэг болон ИНД-91-д нийцүүлэх үүднээс, 1-р ангиллын хэт хөнгөн нисдэг тэргийг 2-р ангиллын хэт хөнгөн агаарын хөлөгт хамааруулна.</p>	
<p><b>103.203. Нислэгийн зөвшөөрлийн шаардлага</b></p> <p>(a) ИНД-91.101(a)(1)(i)-ийн шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.</p> <p>(b) Энэ Дүрмийн дагуу олгосон нислэгийн зөвшөөрөл, эсхүл нислэгийн түр зөвшөөрөл нь тухайн агаарын хөлөгт хүчинтэй байхаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй байх үүрэгтэй.</p>	<p><b>103.199. Нислэгийн зөвшөөрөлд тавигдах шаардлага</b></p> <p>(a) ИНД 91-д заасан шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчид хамаарахгүй.</p> <p>(b) Аливаа этгээдийг, энэ дүрмийн дагуу нислэгийн зөвшөөрөл, эсхүл түр зөвшөөрөл олгогдоогүй 2-р ангиллын хэт хөнгөн агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>103.205. Нислэгийн зөвшөөрөл авах <u>хүсэлт гаргах</u></b></p> <p>Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөгт нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь 103.207-д шаардсан мэдээллийг зохих төлбөрийн баримтын хамт <u>Даргад</u> хүргүүлнэ.</p>	<p><b>103.201. Нислэгийн зөвшөөрөл авах</b></p> <p>(a) 2-р ангиллын хэт хөнгөн агаарын хөлөгт нислэгийн зөвшөөрөл авах аливаа этгээд энэ дүрмийн 103.203-д заагдсан мэдээлэл, баримтыг бүрдүүлэн, зохих төлбөрийн баримтын хамт <u>ИНЕГ</u>-т ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга найруулга зассан.</p>
<p><b>103.207. Нислэгийн зөвшөөрөл олгох</b></p> <p>(a) Дарга дараах тохиолдолд Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөл олгож болно, хэрэв:</p> <p>(1) нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь дараах нотлох баримтыг хүргүүлсэн бол:</p> <p>(i) ИКАО-гийн Хэлэлцэн тохирогч улсын холбогдох эрх бүхий байгууллагаас тухайн маягт олгосон хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөл, эсхүл түүнтэй дүйцэх Даргын хүлээн зөвшөөрөхүйц баримт бичиг; эсхүл</p> <p>(ii) <u>тухайн агаарын хөлгийн маягийн загвар нь дараах аль нэг стандартыг хангаж байгааг:</u></p> <p><u>(A) UKCAA-ийн гаргасан Британийн Иргэний Нисэхийн НТЧ-ын Шаардлага Хэсэг S (1983 оны 03 сарын CAP 482 болон түүний 1988 оны 10 сарын өөрчлөлт);</u></p> <p><u>(B) Австралийн CASA-ийн гаргасан 95.32 дугаартай (1990 оны 02 сарын 28-ны Хэвлэл 1 ба 1990 оны 08</u></p>	<p><b>103.203. Нислэгийн зөвшөөрөл олгох</b></p> <p>(a) Дараах шаардлага хангагдсан тохиолдолд аливаа этгээдийн 2-р ангиллын хэт хөнгөн агаарын хөлөгт нислэгийн зөвшөөрөл олгоно:</p> <p>1/ бүрдүүлсэн байх бичиг баримт:</p> <p>1.1 Чикагогийн Конвенцийн хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагаас олгосон хэт хөнгөн агаарын хөлгөөр нислэг үйлдэх зөвшөөрөл, эсхүл түүнтэй ижил хүчин төгөлдөр баримт, эсхүл</p>	<p>- Агаарын хөлгийн маягийн загварын стандарт нэмэгдсэн</p> <p>- ангилал 2-ын микролайт агаарын хөлгийн хангасан байж болох стандартууд</p>



[сарын 01-ний 57-р нэмэлт, өөрчлөлт](#)) болон [101.55 дугаартай \(1988 оны 01 сарын 07-ны Хэвлэл 1 ба 1991 оны 08 сарын 28-ны 90-р нэмэлт, өөрчлөлт\)](#) тушаал;

[\(C\) Канадын Тээврийн Яамнаас гаргасан TP10141E Баримт;](#)

[\(D\) Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад дүйцэх стандарт;](#) эсхүл

(iii) тухайн маягийн 6, эсхүл түүнээс дээш агаарын хөлөг ашиглаж байгаа ба тэдгээр нь нийт 150-иас доошгүй цагийн нислэг, үүнээс нэг агаарын хөлөг нь 50-иас доошгүй цагийн нислэг үйлдэхдээ НТЧ-ын түүх нь шаардлага хангасан түвшинд хүрснийг нотлох баримт; эсхүл

(iv) тухайн агаарын хөлөгт энэ зүйлийн (b)-гийн дагуу нислэгийн түр зөвшөөрөл олгосон ба 103.211-д заасны дагуу ашиглалтын хугацаа тогтоох тестийг амжилттай хийсэн тухай баримт бичиг;

(2) хүсэлт гаргагч нь дараах баримт бичиг хүргүүлсэн бол:

(i) тухайн агаарын хөлөг [нь ИНД-47, 91 болон 103-ын дагуу холбогдох бүх шаардлагыг хангаж байгааг](#) хангалттай нотлох баримт;

(ii) тухайн агаарын хөлгийн өмнөх нислэгийн зөвшөөрөл, эсхүл түүнтэй дүйцэх баримт бичиг олгосноос хойш ниссэн цаг болон нийт нислэгийн цагийн мэдэгдэл;

(iii) хэт хөнгөн агаарын хөлөг, эсхүл түүний хөдөлгүүр, эсхүл хөдөлгүүрийн бүрдэл хэсэгт үйлдвэрлэгчийн заавал хийх шаардлагатай гэж үзсэн үзлэг шалгалт, эд ангийн солилт, их засвар, эсхүл бусад техник үйлчилгээг хийсэн тухай мэдэгдэл;

(3) агаарын хөлөгт Даргаас эрх олгосон этгээд үзлэг шалгалт хийж ИНД-91.617-д шаардсан холбогдох техник үйлчилгээний бүртгэлд тухайн агаарын

1.2 ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөхүйц маягийн стандартын шаардлага хангасныг баталсан баримт, эсхүл 1.3 тухайн агаарын хөлгийн маягаас 6 буюу түүнээс дээш тооны агаарын хөлөг ашиглалтад байгаа бөгөөд тэдгээр нь нийт 150-иас доошгүй цагийн, мөн тэдгээрээс нэг нь 50-иас доошгүй цагийн нислэг үйлдсэн гэх баталгаа, эсхүл

1.4 тухайн агаарын хөлөгт энэ зүйлийн (б)-гийн дагуу түр зөвшөөрөл олгогдсон ба энэ дүрмийн 103.207 -гийн дагуу бөх бат чанарыг нь шалгасан тухай баталгаа.

2/ бүрдүүлсэн байх бичлэг, тэмдэглэл:

2.1 агаарын хөлөг нь холбогдох [ИНБД-ийн бүх шаардлагыг хангасан гэдгийг бататгах баримт;](#)

2.2 тухайн агаарын хөлгийн нийт ниссэн цаг болон өмнө олгогдсон нислэгийн зөвшөөрөл, эсхүл түүнтэй адил төстэй бичиг баримт олгогдсоноос хойшхи нислэгийн цагийн баримт;

2.3 хэт хөнгөн агаарын хөлөг, эсхүл түүний хөдөлгүүр буюу хөдөлгүүрийн эд ангид үйлдвэрлэгчээс зайлшгүй хийсэн байх аливаа үзлэг, их засвар бусад үйлчилгээний баримт.

3/ тухайн агаарын хөлгийг ИНЕГ-ын даргаас эрх олгогдсон этгээд шалгаж ИНД-91-д заагдсан техник үйлчилгээний зохих баримт дээр нь уг

- Amend.6-аар нэмэгдсэн

<p>хөлөг нь загварын аюултай хэв шинжгүй болохыг баталгаажуулсан бол.</p> <p><u>(b) Дарга, Монгол Улсад зохион бүтээж, үйлдвэрлэсэн Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн эх загвар нь энэ зүйлийн (a)(1)(i), (ii), эсхүл (iii)-ын шаардлагыг хангаагүй боловч, хэрэв тухайн агаарын хөлгийн эх загвар НТЧ-ын холбогдох шаардлагын дагуу далавчны статик ачааллын болон дугуйн дээр унагаах туршилт тестэд тэнцсэн бол тухайн хэт хөнгөн агаарын хөлөгт нислэгийн түр зөвшөөрөл олгож болно.</u></p> <p>(c) Энэ зүйлийн (b)-гийн дагуу олгосон хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн түр зөвшөөрөл нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <p>(1) нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж Даргын үзсэн үйл ажиллагааны хязгаарлалтыг агуулсан байх;</p> <p>(2) 6 сараас дээш хугацаагаар олгогдохгүй байх.</p> <p><u>(d) Хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн түр зөвшөөрлийн эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь нислэгийн түр зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны хязгаарлалтыг мөрдөх үүрэгтэй.</u></p> <p><u>(e) Хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөл нь түүний хугацаа дуусах, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй байна.</u></p>	<p>агаарын хөлөг бүтцийн хувьд аюулгүй болох тухай тэмдэглэл хийсэн байна.</p> <p>(б) ИНЕГ нь, хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн хязгаарлалтуудаас хамааран, нислэгийн аюулгүй ажиллагааны эрх ашгийн үүднээс, нислэгийн зөвшөөрлийг түр хугацаагаар олгож болно.</p> <p>(в) Энэ зүйлийн (a)-д заасан зөвшөөрлийг агаарын хөлгийн ашиглалтын нийт хугацаагаар ба түр зөвшөөрлийн хувьд хуанлийн 6 сар хүртэл хугацаагаар олгоно.</p>	<p>-Amend.6-аар нэмэгдсэн</p> <p>-Amend.6-аар нэмэгдсэн</p>
<p><b>103.209. Модификаци</b></p> <p>Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөгт түүний НТЧ-т нөлөөлж болох хэлбэрээр модификаци хийсэн бол, тухайн үйл ажиллагаа эрхлэгч нь дараагийн нислэг үйлдэхээс өмнө <u>103.207-д</u> заасан шаардлагыг хангах зорилгоор тухайн агаарын хөлөгт дахин үзлэг шалгалт хийж, үнэлгээ хийсэн болохыг бататгана.</p>	<p><b>103.205. Шинэчлэлт</b></p> <p>(a) 2-р ангиллын хэт хөнгөн агаарын хөлөгт, түүний нислэгт тэнцэх чадварт нөлөөлж болохуйц өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн тохиолдолд аливаа нислэг үйлдэхээс өмнө энэ дүрмийн <u>103.203-ийн</u> дагуу дахин үзлэг хийгдэж үнэлгээ олгогдсон байна гэдгийг тухайн агаарын хөлгийг ашиглагч бататгана.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p> <p>Modification-ийг “шинэчлэлт” гэснийг “модификаци” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>103.211. Ашиглалтын тест хийх</b></p> <p>(a) Хэт хөнгөн агаарын хөлгийн ашиглалтын тест нь дараах нислэгээс бүрдэнэ:</p>	<p><b>103.206. Бөх бат чанарыг шалгах</b></p> <p>(a) Хэт хөнгөн агаарын хөлгийн бөх бат чанарыг дараах хугацаанд шалгана:</p>	

<p>(1)зургийн дагуу, бэлдэц материалаар бүтээсэн агаарын хөлгийн хувьд, 40 цагийн нислэг; эсхүл</p> <p>(2)бэлдэц материалын иж бүрдэл (kitset) бэлдцээр бүтээсэн хэд хэдэн агаарын хөлгийн хувьд, 25 цагийн нислэг; эсхүл</p> <p>(3)урьдчилан бэлдсэн бүрдэл хэсгийн иж бүрдэл (kitset) бэлдцээр бүтээсэн хэд хэдэн агаарын хөлгийн хувьд, 10 цагийн нислэг; эсхүл</p> <p>(4)бүхэлдээ, зөвхөн урьдчилан үйлдвэрлэсэн үйлдвэрийн бүрдэл хэсэг болон угсарсан иж бүрдлээр бүтээсэн хэд хэдэн агаарын хөлгийн хувьд, <u>2 цагийн</u> нислэг.</p> <p>(b) Модификаци хийсний эсхүл эвдрэл, гэмтэл гарсны дараа ашиглалтын тестийг дахин эхлүүлнэ.</p>	<p>1/төмөр холбоос ба үйлдвэрлэлийн бус аргаар хийгдсэн материалаар хийсэн агаарын хөлгийн хувьд 40 цагийн нислэг, эсхүл</p> <p>2/ үйлдвэрлэлийн бус аргаар хийгдсэн эд анги, материалаар хийсэн агаарын хөлгийн хувьд 25 цагийн нислэг, эсхүл</p> <p>3/үйлдвэрлэлийн аргаар хийсэн эд анги, материалаар хийсэн агаарын хөлгийн хувьд 10 цагийн нислэг, эсхүл</p> <p>4/ урьдчилан үйлдвэрлэсэн бэлдэц, эд ангиар хийсэн агаарын хөлгийн хувьд <u>10 цагийн</u> нислэг.</p> <p>(б) Бөх бат чанарыг, агаарын хөлөг эвдрэл гэмтэлд орсны дараа, эсхүл өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн тухай бүр шалгана.</p>	<p>-10 цагийн нислэг-2 цагийн нислэгээс бүрдэнэ</p>
<p><b>103.213. НТЧ-ын мэдэгдэл</b> Энэ дүрмийн <u>103.211-ийн</u> дагуу ашиглалтын тест хийсэн хэт хөнгөн агаарын хөлгийн дарга нь ИНД-91.617-д шаардсан техник үйлчилгээний бүртгэлд дараах бичилтийг оруулах үүрэгтэй:</p> <p>(1) тестийн үед гүйцэтгэсэн бүх маневрын дэлгэрэнгүйг, түүнийг гүйцэтгэсэн нислэгийн хурдны дэлгэрэнгүй мэдээллийн хамт;</p> <p>(2) дараах мэдэгдлийн (гүйцэтгэсэн нислэгийн цагийг багтаасан араас сүүлчийн тест хийсэн нисгэгчийн нэр, гэрчилгээ, эсхүл үнэмлэхний дугаар, гарын үсэг болон огноог бичих:</p> <p>Энэ агаарын хөлгөөр ИНД-103-ын шаардлагад нийцүүлэн .... цагийн нислэгийг амжилттай гүйцэтгэсэн ба тухайн агаарын хөлөг нь тохирсон техникийн үзүүлэлттэй бөгөөд хурдны боломжит хязгаарын хооронд удирдагдаж байгааг бүх маневрыг гүйцэтгэснээр тогтоосон бөгөөд НТЧ-тай болохыг Би баталж байна.</p>	<p><b>103.207. Нислэгт тэнцэх чадвар</b></p> <p>(a) Хэт хөнгөн агаарын хөлгийн дарга нь энэ дүрмийн <u>103.206-ийн</u> дагуу бөх бат чанарыг шалгасны дараа техник үйлчилгээний бичиг баримтад ИНД 91-д шаардсаны дагуу дараах тэмдэглэл хийнэ:</p> <p>1/ нислэгийн хурд болон бүх төрлийн жолоодлогын талаар;</p> <p>2/ Нисгэгчийн нэр, гэрчилгээ, үнэмлэхний дугаар болон ниссэн цаг, он сар өдөр, гарын үсэг бүхий дараах бичилтийг хийнэ :</p> <p>Энэхүү агаарын хөлөг нь ИНД-103 -ын дагуу . . . . цагийн нислэгийг хангалттай түвшинд гүйцэтгэсэн ба нислэгийн үйл ажиллагааны зохих чадвартай, хурдны хэвийн хязгаарлалтад бүх төрлийн жолоодлогыг гүйцэтгэх боломжтой, нислэгт тэнцэх чадвартай болохыг тодорхойлов.</p> <p>..... он.....сар.....өдөр Гарын үсэг.....</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>103.215. Нөөц</b> <b>103.217. Техник үйлчилгээ болон үзлэг шалгалтын шаардлага</b></p>	<p><b>103.209. Техник үйлчилгээ ба үзлэгт тавигдах шаардлага</b></p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

(a) Хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

(1) тухайн агаарын хөлөгт нислэгт тэнцэх нөхцөлийг хангасан техник үйлчилгээ хийсэн байх;

(2) ИНД-39-д шаардсаны дагуу холбогдох бүх НТЧ-ын удирдамжийг биелүүлсэн байх;

(3) шаардлагатай үзлэг шалгалтын хооронд бүх гэмтэл дутагдлыг зассан байх.

(b) Энэ дүрмийн 103.207(а)(1)-д заасан маягийн загварын стандартыг хангаж байгаа хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, тухайн агаарын хөлөг нь зохион бүтээгчийн, эсхүл иж бүрдэл үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний шаардлагын дагуу ашиглагдаж байгааг бататгах үүрэгтэй.

(c) Энэ зүйлийн (d) болон (g)-г харгалзан, дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх үүрэгтэй:

(1) тухайн агаарын хөлгийн төлөв байдлын жилийн үзлэг шалгалтыг өмнөх 12 сарын дотор хийсэн байх;

(2) энэ зүйлийн (а)(2)-ыг хангасан байх;

(3) энэ зүйлийн (h)-д зааснаас бусад тохиолдолд, дараах дүрмийн дагуу шаардсан холбогдох тест болон үзлэг шалгалт хийгдсэн байх шаардлагыг хангасан байх:

(i) ИНД-91.605(е)(2)-автомат даралтын түвшнийг мэдээлэх системийн үзлэг шалгалт болон тестийн талаар, хэрэв хэт хөнгөн агаарын хөлгийг ажиглалтын транспондероор тоногдсон бол;

(ii) ИНД-91.605(е)(3), хэрэв хэт хөнгөн агаарын хөлгийг ажиглалтын транспондероор тоногдсон бол;

(iii) ИНД-91.605(е)(8), хэрэв хэт хөнгөн агаарын хөлгийг хөвөгч төхөөрөмжөөр тоногдсон

(a) Хэт хөнгөн агаарын хөлгийг ашиглагч нь тухайн агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалтыг хариуцана.

(б) **Хэт хөнгөн** агаарын хөлгийг ашиглагч нь тухайн агаарын хөлөг энэ дүрмийн 103.307-ийн (а)-гийн 1/-д заагдсан загвар, маягийн стандартыг хангаж байгаа ба агаарын хөлгийг зохион бүтээгчээс, эсхүл үйлдвэрлэгчээс тогтоосон техник үйлчилгээний шаардлагыг мөрдөж байгаа гэдгийг бататгана.

(в) Хэт хөнгөн агаарын хөлөг нь өмнөх 12 сарын дотор жил тутмын үзлэгт ороогүй тохиолдолд аливаа этгээд түүнийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж болохгүй.

-Микролайт агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн үүргийг нарийвчилж/дэлгэрүүлж заасан (NZ revision)

-Amend.6-аар нэмэгдсэн

-Орчуулга, найруулга зассан

бол.

(d) Энэ зүйлийн (с)(1)-д шаардсан жилийн төлөв байдлын үзлэг шалгалт (annual condition inspection) нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

(1) дараах этгээд хийсэн байх:

- (i) хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагаас жилийн төлөв байдлын үзлэг шалгалт хийх эрх олгогдсон; эсхүл
- (ii) Даргаас эрх олгогдсон; эсхүл

(iii) ИНД-66-гийн дагуу олгосон агаарын хөлөг болон хөдөлгүүрийн бүлгийн зэрэглэлтэй агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн хүчинтэй үнэмлэх (AMEL) эзэмшдэг;

(2) үзлэг шалгалт хийсэн эд зүйл, бүрдэл хэсгийн хувьд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц.

(e) Энэ зүйлийн (с)(1)-д шаардсан жилийн төлөв байдлын үзлэг шалгалт хийж байгаа этгээд, хэрэв тухайн агаарын хөлөг нь НТЧ-тай нөхцөлд байгааг тогтоосон бол, дараах үүрэгтэй:

- (1) үзлэг шалгалтын маягтад тухайн агаарын хөлөг НТЧ-тай болохыг баталгаажуулах;
- (2) энэ зүйлийн (е)(1)-д шаардсан үзлэг шалгалтын маягтыг тухайн агаарын хөлгийн орох хаалганы дэргэд, ил харагдахуйц хэсэгт хөдөлгөөнгүй байрлуулах;
- (3) энэ зүйлийн (е)(1)-д шаардсан үзлэг шалгалтын маягтын хуулбарыг тухайн гэрчилгээжүүлэлтийн баримт бичгийн хэлбэрээр хадгалах;
- (4) Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн хувьд, ИНД-91.617-д шаардсан техник үйлчилгээний бүртгэлд гэрчилгээжүүлэлтийн дэлгэрэнгүй мэдээллийн бичилтийг оруулах.

(f) Энэ зүйлийн (е)(1)-ийн дагуу шаардсан агаарын хөлгийн үзлэг шалгалтын маягтад дараах мэдээллийг тусгах шаардлагатай:

- (1) агаарын хөлгийн бүртгэлийн дугаар;
- (2) агаарын хөлгийн маяг;

(г) Энэ зүйлийн (в)-д заагдсан үзлэг нь:

1/ дараах этгээдээр гүйцэтгэгдэнэ:

1.1 ИНЕГ-аас, жилийн үзлэг гүйцэтгэх эрх олгогдсон, эсхүл

1.2 ИНД-66-ын дагуу олгогдсон хөдөлгүүр болон их биений зэрэглэлтэй, техник үйлчилгээний ажилтны хүчин төгөлдөр үнэмлэхтэй,

2/ **ИНД-43 -ын Хавсралт В-д заагдсан эд анги, зүйлсийг хамарсан байна.**

(д) Энэ зүйлийн (в)-д **заагдсан** үзлэгийг гүйцэтгэсэн этгээд тухайн агаарын хөлгийг нислэгт тэнцэх чадвартай гэж үзвэл:

1/ гэрчилгээ олгох ба гэрчилгээг агаарын хөлөг дотор, ил харагдахуйц газар байрлуулахыг шаардана;

2/ энэ хэсгийн 1/-д заасан гэрчилгээний хуулбарыг үзлэгийн тайланд хавсаргана;

3/ 2-р ангиллын хэт хөнгөн агаарын хөлгийн хувьд, ИНД 91-д заасан техник үйлчилгээний бичиг баримтад гэрчилгээжүүлсэн тухай **тэмдэглэл хийнэ.**

(е) Энэ зүйлийн (д)-гийн 1/-д заасан гэрчилгээнд дараах зүйл тусгагдана:

- 1/ агаарын хөлгийн бүртгэлийн таних тэмдэг;
- 2/ агаарын хөлгийн маяг;
- 3/ ээлжит болон жил тутмын үзлэг хийгдэх огноо;

-“Дарга хүлээн зөвшөөрөхүйц байх” гэж өөрчилсөн (NZ revision)

-Орчуулга найруулга зассан

<p>(3) жилийн төлөв байдлын дараагийн үзлэг шалгалт хийх үлдсэн өдөр;  (4) жилийн төлөв байдлын үзлэг шалгалт хийсэн инженер, эсхүл шалгагчийн гарын үсэг, үнэмлэх, эсхүл гэрчилгээний дугаар, үзлэг хийсэн огноо.</p> <p>(g) Хэрэв энэ зүйлийн (c)(1)-д шаардсан жилийн төлөв байдлын үзлэг шалгалтаар тухайн агаарын хөлгийг нислэгт тэнцэхгүй болохыг тогтоосон бол, агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (d), (e) болон (f)-д шаардсаны дагуу дахин үзлэг шалгалт хийж нислэгт тэнцэхийг баталгаажуулах хүртэл тухайн агаарын хөлгийг нисгэхийг зөвшөөрөхгүй.</p>	<p>4/ жил тутмын үзлэгийг гүйцэтгэсэн этгээдийн гарын үсэг, үнэмлэх, гэрчилгээнийх нь дугаар, үзлэг хийгдсэн огноо;</p> <p>(ж) Энэ зүйлийн (в)-д заагдсан үзлэгээр хэт хөнгөн агаарын хөлөг нислэгт тэнцэх чадваргүй гэж тогтоогдвол уг агаарын хөлгийг энэ зүйлийн (д)-гийн дагуу гэрчилгээ олгогдох хүртэл нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж болохгүй.</p>	
<p><b>103.219. <u>Үйлдвэрлэл</u></b>  Хэрэв хэт хөнгөн агаарын хөлгийг дараах бэлдцээр бүтээж байгаа бол, тухайн этгээдийг ИНД-148-ыг дагаж мөрдөхийг шаардахгүй:</p> <p>(1) зургийн дагуу, бэлдэц материалаар; эсхүл</p> <p>(2) бэлдэц материалын иж бүрдлээр (kitset); эсхүл</p> <p>(3) урьдчилан бэлдсэн бүрдэл хэсгийн иж бүрдлээр (kitset); эсхүл</p> <p>(4) урьдчилан үйлдвэрлэсэн үйлдвэрийн бүрдэл хэсэг болон иж бүрдлээр.</p>	<p><b>103.211. Бүтэц</b></p> <p>(a) Дараах эд анги, материалаар хэт хөнгөн агаарын хөлөг бүтээж буй этгээд ИНД-148-ын шаардлагыг дагаж мөрдөх шаардлагагүй:</p> <p>1/ төмөр холбоос ба үйлдвэрлэлийн бус аргаар хийгдсэн материал, эсхүл</p> <p>2/ үйлдвэрлэлийн бус аргаар хийгдсэн эд анги, материал, эсхүл</p> <p>3/ үйлдвэрлэлийн аргаар хийсэн эд анги, материал, эсхүл</p> <p>4/ урьдчилан үйлдвэрлэсэн бэлдэц, эд анги.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>103.221. Хэрэглэл болон төхөөрөмжийн шаардлага</b></p> <p>(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн агаарын хөлгийг дараах байдлаар тоноглосон байна:</p> <p>(1) шаардлагатай хэрэглэл болон төхөөрөмж нь:</p> <p>(i) тухайн агаарын хөлгийн маягийн загварт нийцсэн байх;</p> <p>(ii) тухайн агаарын хөлгийн зохион бүтээгч, эсхүл иж бүрдэл үйлдвэрлэгчийнх байх.</p> <p>(2) дараах мэдээллийг зааж үзүүлдэг байх:</p> <p>(i) агаарын хурд;</p> <p>(ii) түвшнийг метрээр;</p>	<p><b>103.213. Хэрэглэл ба тоног төхөөрөмжид <u>тавигдах</u> шаардлага</b></p> <p>(a) Энэ зүйлийн (б)-г харгалзан үзсэнээр, хэт хөнгөн агаарын хөлгийг ашиглагч нь уг агаарын хөлгийг дараах хэрэглэл, тоноглолоор тоноглосон байна:</p> <p>1/ агаарын хөлгийн загвар, маягт нийцсэн, зохион бүтээгчээс, эсхүл бэлдэц үйлдвэрлэгчээс шаардсан хэрэглэл, тоног төхөөрөмж;</p> <p>2/ хурд заагч, өндөр хэмжигч, соронзон чиглэл заагч хэрэглэлүүд.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Бусад дүрэм рүү ишлэл хийсэн заалтуудыг тодорхой</p>

<p>(iii) соронзон чиглэл.</p> <p>(b) Моторт-шүхрээр үйл ажиллагаа эрхлэгчийг, тухайн агаарын хөлгийг агаарын хурд заах хэрэгслээр тоноглохыг шаардахгүй.</p> <p>(c) <b>ИНД-91-ийн F Бүлэгт</b> заасан дараах шаардлага хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй:</p> <p>(1) <b>ИНД-91.509</b>-д шаардсан минимум хэрэглэл болон төхөөрөмжийн хувьд, <b>ИНД-91.501(1)</b>;</p> <p>(2) Хавсралт А-ын А3-т заасан суудлын стандартын хувьд, <b>ИНД-91.501(2)(i)</b>.</p>	<p>(б) Моторт шүхрийг хурд заагчтай байхыг шаардахгүй.</p> <p>(в) <b>ИНД-91</b>–д заагдсан дараах шаардлагууд хэт хөнгөн агаарын хөлөгт хамаарахгүй:</p> <p>1/ <b>ИНД-91-д</b> шаардсан хамгийн цөөн хэрэглэл, тоног төхөөрөмжид,</p> <p>2/ <b>ИНД-91–ийн Хавсралт А</b>-заагдсан суудлын стандартад.</p>	<p>болгосон</p>
<p><b>103.223. Ханг-глайдер чирэх агаарын хөлөг</b> Хэт хөнгөн агаарын хөлгөөр нислэгт <b>ханг-глайдер</b> чирэх үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь 103.221-ийн шаардлагаас гадна, дараах шаардлагыг хангасан болохыг бататгана:</p> <p>(1) тухайн агаарын хөлгийг дараах хэрэгслээр тоноглогсныг:</p> <p>(i) чирж байгаа нисгэгчид ямар ч үед чирэх холбоосыг салгах боломжийг бүрдүүлэх, тухайн агаарын хөлгийн загвар хийцийн стандартад нийцсэн чирэх дэгээ болон бэхэлгээний иж бүрдлийг багтаасан чирэх хэрэгсэл;</p> <p>(ii) ар талаа харах толь;</p> <p>(iii) чирж байгаа онгоцны төгсгөлд 100 кг-аас ихгүй таслах хүчинд түрүүлж тасрах холбоосоор (weak link) тоноглогсон чирэх татлага.</p> <p>(2) тухайн <b>ханг-глайдер</b>ыг дээшээ 45°, доошоо 30°, хоёр тийш 30° өнцөгтэй конус дотор, чирэх татлагад 100 кг-аас дээш ачаалал үүсэхэд <b>ханг-глайдер</b>ын нисгэгч ажиллуулдаг, чирэх гогцооны арын үзүүрийг хялбар, найдвартай салгах үйлдэлтэй механизмаар тоноглогсныг.</p>	<p><b>103.215. Дельтаплан чирэх агаарын хөлөг</b></p> <p>(a) <b>Дельтаплан</b> чирэх хэт хөнгөн агаарын хөлгийг ашиглагч нь энэ дүрмийн 103.213-аас гадна, дараах зүйлийг бататгана:</p> <p>1/ агаарын хөлөгт дараах тоноглолууд суурилагдсан гэдгийг:</p> <p>1.1 уг агаарын хөлгийн хийцийн стандартад нийцсэн чирэх дэгээ ба бэхэлгээ төхөөрөмж /чирж байгаа агаарын хөлгийн Нисгэгч нь шаардлагатай үед холбоосыг нь салгах боломжтой байна/,</p> <p>1.2 ар талаа харах толь,</p> <p>1.3 чирэх уяаны <b>дельтаплан</b> талын үзүүр хэсэг нь 100 кг-аас дээш жинтэй зүйлийг чирэхэд тасрахаар байх.</p> <p>2/ дээшээ 45 градус, доошоо 30 градус, хажуу тийш 30 градусын өнцгөөр чирэгдэх тохиолдолд чирэх уяаны арын үзүүрт 100кг-аас дээш ачаалал үүсэхэд <b>дельтапланы</b> Нисгэгч нь уяаг хялбархан мулталж суллах боломжтой механизмаар тухайн <b>дельтапланыг</b> тоноглогсон гэдгийг.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p> <p>-“Дельтаплан” гэснийг “Ханг-глайдер” гэж өөрчлөгдсөн</p>

Дүрмийн боловсруулалтын хэлтэс